

ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО, МӨНГӨН ХӨРӨНГИЙН ГҮЙЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Ерөнхий үндэслэл

1.1 Энэхүү журам нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын арилжааны болон биржийн бус арилжааны үнийн дүнд үүссэн төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн гүйлгээг хийж гүйцэтгэх явцад үүсэх харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү харилцаанд МУ-ын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, СЗХ-ны “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”, “Монгол банкны банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам”, “Монгол банкны банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны журам” НББ-ын олон улсын стандарт болон “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХКомпанийн уг журмыг удирдлага болгоно.

1.3 Үнэт цаасны арилжааны болон биржийн бус арилжааны хэлцлийн дүнд үүссэн төлбөр тооцоо, мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбогдсон төлбөр тооцоог “ҮЦТТТХТ” ХХК-ийн Төлбөр тооцоо-эрсдлийн удирдлагын алба\цаашид Алба гэх\ хийж гүйцэтгэнэ.

Хоёр. Журмын нэр томъёо

2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

2.1.1 “үнэт цаас” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.1.1-д зааснаар ойлгох;

2.1.2 “биет үнэт цаас” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.1.2-т зааснаар ойлгох;

2.1.3 “биет бус үнэт цаас” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.1.3-т зааснаар ойлгох;

2.1.4 “сдеро” гэж дансны үлдэгдэл санг хэлнэ;

2.1.5 “сдеро санд нөлөөлүүлэх” гэж дансны үлдэгдэл санд өөрчлөлт оруулахыг;

2.1.6 “мөнгөн хөрөнгийн баланс” гэж дансны үлдэгдэл сан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь өмнөх өдрийн үлдэгдэл дээр тухайн өдрийн орлогыг нэмж, зарлагыг хасч гаргасан үлдэгдэлтэй тэнцэх тэнцвэрийг;

2.1.7 “баталгаажигдсан хэлцэл” гэж арилжаа эрхлэх байгууллагаас баталгаажуулсан арилжааны хэлцэл

2.1.8 “арилжааны шимтгэл” гэж арилжааны үнийн дүнгээс тодорхой хувиар тооцсон дүн;

2.1.9 “арилжааны хуулгын сан” гэж өдрийн арилжаа явагдаад дууссаны дараа брокер, дилерийн компаниудад /цаашид БДК гэж/ хүргүүлэх арилжааны болон дансны үлдэгдлийн мэдээллийн санг;

2.1.10 “дансны хуулга” гэж харилцагчийн дансанд хийгдсэн гүйлгээний болон үлдэгдлийн мэдээ;

2.1.11 “анхан шатны баримт” –д мөнгө олгохыг хүссэн өргөдөл, мөнгөн хөрөнгө шилжүүлэх өргөдөл, мөнгөн хөрөнгийн орлогын баримтууд /төлбөрийн даалгавар, шаардлагатай тохиолдолд кассын орлогын ордер/

2.1.12 “Т+0” гэж арилжаа хийгдсэн өдөрт нь төлбөр тооцоог гүйцэтгэх хугацааг;

2.1.13 “Т+1” гэж арилжаа хийгдсэн ажлын 1 өдрийн дараа төлбөр тооцоо хийж гүйцэтгэх хугацаа;

2.1.14 “Т+2” гэж арилжаа хийгдсэн ажлын 2 дах өдөрт төлбөр тооцоог хийж гүйцэтгэх хугацаа;

2.1.15 “гүйлгээний хугацаа” гэж төвлөрсөн хадгаламжид мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ хийх хугацааг хэлнэ.

2.1.16 “их дүнтэй гүйлгээ” гэж Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан хязгаартай тэнцүү буюу түүнээс дээш үнийн дүнтэй банк хоорондын гүйлгээг;

2.1.17 “бага дүнтэй гүйлгээ” гэж Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан хязгаартай тэнцүү буюу түүнээс доош үнийн дүнтэй банк хоорондын гүйлгээг;

2.1.18 “Сан” гэж мэдээллийн төвлөрсөн санд хадгалагдаж байгаа өгөгдлийг хадгалж буй хүснэгт;

2.1.19 “Орлогын гүйлгээ” гэж Арилжааны банкнаас “ҮЦТТТХТ” ХХК-ийн данс руу хийсэн гүйлгээ;

2.1.20 “Бусад орлого” гэж Арилжааны банкинд байршдаг “ҮЦТТТХТ” ХХК-ийн харилцах дансанд хийгдсэн гүйлгээ

2.1.21 “Зарлагын гүйлгээ” гэж “ҮЦТТТХТ” ХХК-ийн данснаас Арилжааны банк руу хийсэн гүйлгээ;

2.1.22 “Бусад зарлага” гэж Арилжааны банкинд байршдаг “ҮЦТТТХТ” ХХК-ийн харилцах данснаас хийгдсэн гүйлгээ

Гурав. Төлбөр тооцооны хэлбэр

3.1 Албаар дамжуулан харилцагчийн дансанд хийгдэх мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоо нь төвлөрсөн хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн бэлэн бус хэлбэртэй байна.

3.2 Биет болон биет бус үнэт цаасны арилжааны үнийн дүнд үүссэн төлбөр тооцоог арилжаа эрхлэх байгууллагаас баталгаажсан хэлцлийг хэвлэмэлээр болон сүлжээгээр баталгаажуулан ирүүлсэнийг үндэслэн хийж гүйцэтгэнэ.

3.3 Биржийн бус арилжааны төлбөр тооцоог Хадгаламж өмчлөх эрх бүртгэлийн алба /ХӨЭБА/-д үнэт цаасны гүйлгээ хийгдсэний дараа үнэт цаас гаргагчийн мэдэгдэлийг үндэслэн гүйцэтгэнэ.

3.4 Засгийн газрын үнэт цаасны төлбөрийн тооцоог “ЗГҮЦ-ыг бүртгэх, хадгалах, төлбөр тооцоо гүйцэтгэх” журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Төлбөр тооцоонд тавигдах шаардлагууд

4.1 Төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрт тавигдах шаардлагыг “ҮЦТТТХТ” ХХК тогтооно.

4.2 Алба нь төлбөр тооцооны анхан шатны баримтыг БДК болон харилцагчаас хүлээн авч, баримтын бүрдлийг шалган арилжаа эхлэхээс 30 минутын өмнө гүйлгээг хааж, Үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад арилжаа явуулахад зориулан үлдэгдлийн файл/данс, үнэт цаас, бэлэн мөнгө/ бэлтгэн сүлжээгээр болон хэвлэмэлээр бүртгэл хөтлөн арилжаа эхлэхээс 15 минутын өмнө мэдэгдэнэ.

4.3 Төлбөр тооцооны мэдээллийн бааз болон програмд алдаа гарсанаас арилжаа эрхлэх байгууллагад мэдээг журмын 4.2-т заасан хугацаанд явуулах боломжгүй болсон тохиолдолд төлбөр тооцоо хийж гүйцэтгэх хугацааг түр зогсоон, энэ тухай албан ёсоор Арилжаа эрхлэх

байгууллагад мэдэгдэнэ. Алдааг ажлын нэг өдөрт багтаан залруулах ба хэрэв тухайн хугацаанд залруулах боломжгүй тохиолдолд нийтэд энэ тухай мэдээлэн, албаны менежер холбогдох мэргэжилтэнүүдийг оролцуулсан ажлын хэсгийг яаралтай зохион байгуулж холбогдох арга хэмжээнүүдийг авч, тухайн өдөртөө Хороонд тайлагнана.

4.4 Төлбөр тооцооны анхан шатны баримтын үзүүлэлтүүд тодорхой, гаргацтай, бүрэн гүйцэд бөглөсөн, засваргүй, тамга /тэмдэг/-р баталгаажиж, данс эзэмшигчийн иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргасан байна. Данс эзэмшигчийг төлөөлөн гүйлгээ хийлгэх тохиолдолд Иргэний хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангасан итгэмжлэлийг үндэслэн төлөөлөгч анхан шатны баримтанд гарын үсэг зурж баталгаажуулна. Хэрэв энэхүү үзүүлэлтүүд дутуу бол баримтыг гүйлгээ хариуцсан ажилтан хүлээн авахаас татгалзана.

4.5 Төлбөр тооцооны анхан шатны баримтыг шалган хүлээн авсан гүйлгээ хариуцсан ажилтан гарын үсгээ заавал бүтэн нэрийн хамт бичнэ.

Тав. Мөнгөн хөрөнгийн гүйлгээ

5.1 Төвлөрсөн хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн гүйлгээнд мөнгөн хөрөнгийн орлого /арилжааны банкнаас “ҮЦТТТХТ” ХХК-ийн дансанд хийгдсэн гүйлгээ/, зарлагын гүйлгээ /“ҮЦТТТХТ” ХХК-ийн данснаас Арилжааны банк руу хийсэн гүйлгээ/, төвлөрсөн хадгаламийн данс хоорондын шилжүүлгийн гүйлгээ хамаарагдана.

5.2 Төвлөрсөн хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн гүйлгээ нь гүйлгээний шинэ өдөр нээгдсэнээр эхэлнэ. Гүйлгээний шинэ өдөр ажлын өдөр бүрийн 9.00 / 9 цаг 10 минутад / эхэлнэ.

5.3 Мөнгөн хөрөнгийн гүйлгээ нь тогтмол цагийн хуваариар ажиллах ба Даваа-Баасан гарагт зарлагын гүйлгээг 09:00-10.30:00, /14:15-16.30/, орлогын гүйлгээг 9:00-10:30 /бусад орлогыг 9:00-10,00 цагт/, /14:00-16.30/ цагийн хооронд гүйцэтгэнэ. Зарлагын гүйлгээний баримтыг Даваа-Баасан гарагт 09.00-13.00, 14.00-17.30 цагт хүлээн авна.

5.4 Яаралтай зарлагын гүйлгээг Төв банкны их дүнтэй төлбөр тооцооны журам"-ын дагуу /16.30-17.30/ хооронд төлбөрийн даалгавараар хийх боломжтой бөгөөд “Монгол банкны үйлчилгээ шимтгэлийн ерөнхий нөхцөлийн”-ийг мөрдөнө.

5.5 Арилжааны банкнаас “ҮЦТТТХТ” ХХК-ийн дансанд хийсэн орлогын гүйлгээг овог нэр, төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар, данс эзэмшигчийн нэр, орлогын утга , бүрэн таарсан тохиолдолд харилцагчийн дансанд шууд байршуулна. Дээрх мэдээллүүд дутуу, зөрсөн, данс нь хаалттай тохиолдолд бага дүнтэй орлогын гүйлгээг Монголбанкны банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны журмын 6.2.6 заалтын дагуу нэг цагийн дотор буцаана.

5.6 Нэр данс зөрсөн, дансандаа байрших боломжгүй их дүнтэй орлогын гүйлгээний хувьд арилжаа дууссаны дараа нэг бүрчлэн зарлагын гүйлгээгээр програмаар буцаана.

5.7 Орлогын гүйлгээний хувьд төвлөрсөн хадгаламжинд данстай харилцагчдын дансанд програмаар байрших ба бусад орлогыг тухайн гүйлгээ хариуцсан нягтлан бодогч байршуулж албаны менежер хянан баталгаажуулна.

5.7.1 Бусад орлогын гүйлгээний хувьд тухайн төрлийн гүйлгээний дансны дугаар, дансны нэр, БДК-ийн нэр зэрэг мэдээллийг тодорхой бичсэн байх шаардлагатай бөгөөд эдгээр мэдээлэл банкны хуулганы тайлбарт бичигдээгүй эсвэл нэр данс зөрсөн, тухайн данс нээгдээгүй зэргээс дансанд байршуулах боломжгүй бол “ нэр данс тодорхойгүй” дансанд бүртгэнэ.

5.7.2 Хүлээгдэж байгаа орлогод бүртгэгдсэн бусад орлогыг харилцагчийн ирүүлсэн мөнгө тушаасан баримттай тулгах, мөнгө тушаасан баримт ирүүлэх боломжгүй бол шаардлагатай мэдээллүүдтэй тулгаж дансанд байршуулна. Харилцагч буцаан арилжааны банкин дахь дансандаа хүлээн авах хүсэлт гаргасан тохиолдолд мөнгө тушаасан баримтыг үндэслэн буцаан шилжүүлэх гүйлгээг хийнэ.

5.8 Төв банкны онлайн дансны хуулгыг үндэслэн Монгол банкин дах харилцах дансны бүртгэлийг албаны ахлах нягтлан бодогч НББ-ын олон улсын стандартын дагуу өдөр бүр нэгдсэн балансыг хөтөлж, албаны менежер хянана. Улирлын эцэст дансны үлдэгдлийн баталгааг гаргаж, төв банкаар баталгаажуулна.

5.9 Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг хийхдээ гүйлгээний нягтлан бодогч анхан шатны баримтыг /Маягт-1/-г БДК-иудаас хүлээн авч компанийн мэдээллийн сан дахь мэдээлэлтэй тулган шалгаж, харилцагчийн төвлөрсөн хадгаламжаас хасалт хийнэ.

5.10 Их дүнтэй зарлагын гүйлгээг албаны менежер, бага дүнтэй зарлагын гүйлгээг албаны ахлах нягтлан бодогч хянаж, гүйлгээг гүйцэтгэнэ.

5.11 Дараах тохиолдолд төвлөрсөн хадгаламжийн данс хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлнэ. Үүнд:

5.11.1 ХК-тай байгуулсан гэрээний дагуу ногдол ашиг, ногдол хувийн мөнгөн хөрөнгө байршуулах;

5.11.2 СЗХ-ны Улсын байцаагчийн актыг үндэслэн мөнгөн хөрөнгө байршуулах;

5.11.3 Компанийн дотоод албадуудаас ирүүлсэн албан бичгийн дагуу мөнгөн хөрөнгө байршуулах;

5.12 Шүүхийн шийдвэрийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн шүүхийн шийдвэр, албан бичгийг үндэслэн харилцагчийн данснаас зарлагын гүйлгээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд гүйцэтгэнэ.

5.13 Төвлөрсөн хадгаламжийн данс нь хаалттай төлөвт буй харилцагчдад тараагдах ногдол ашиг, ногдол хувийн мөнгөн хөрөнгийг ХӨЭБА-аас баталгаажуулсан жагсаалтыг үндэслэн тухайн харилцагчийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулна.

5.14 ТТЭУА-ны менежер нь гүйлгээг мөнгөн хөрөнгийн гүйлгээний баримтын бүрдэл дутуу, сэжиг бүхий тохиолдол болон зээлийн барьцаа болон тусгаарлалтанд байгааг шалгах зэрэг үндэслэлээр тухайн гүйлгээнд нэг өдрийн турш хориг тавих эрхтэй бөгөөд гүйлгээнд хориг тавьж байгаагаа холбогдох БДК болон харилцагчид тухайн өдөртөө багтаан мэдэгдэнэ.

5.15 Монголбанкны банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны журмын дагуу “ҮЦТТТХТ” ХХК-ийн харилцах данснаас гүйлгээ хийгдсэн тохиолдолд гүйлгээ буцахгүй.

5.16 Албаны гүйлгээний ажилтнууд сэжиг бүхий гүйлгээний тухай мэдээллийг тухай бүр Дотоод Хяналтын Албанд өгнө.

5.17 Мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх явцад систем дээр ямарваа нэгэн доголдол гарах тохиолдолд МТА болон ДХА-нд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

5.18 Төлбөр тооцооны тасралтгүй ажиллагааг хангах үүднээс Монгол банкны их дүнтэй төлбөр тооцооны журмын 13 дугаар бүлгийг дагаж мөрдөнө.

Зургаа. Төлбөр тооцоо хийхэд хориглох зүйлс

6.1 ТТЭУА-ны ажилтнуудад дараах зүйлийг хориглоно. Үүнд:

6.1.1 баримтын бүрдэл дутуу, мэдээллийн баазтай баримтын мэдээлэл зөрсөн, зохих зөвшөөрөлгүй гүйлгээ хийх, баримтыг хуурамчаар бүрдүүлэх, нуун дарагдуулах; холбогдох БДК-аар баталгаажаагүй, тамга тэмдэггүй, гарын үсэггүй баримтаар гүйлгээ хийх, тодорхой шалтгаангүйгээр орлогын гүйлгээг буцаах;

6.1.2 факс болон И-мэйл, скайнардан ирсэн анхан шатны баримтаар гүйлгээ хийх;

6.1.3 мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг төвлөрсөн хадгаламжид данс эзэмшигч этгээдээс өөр этгээдийн харилцах дансанд шилжүүлэх /насанд хүрээгүй хүүхдийн дансанд хамаарахгүй/;

6.1.4 зарлагын гүйлгээ гаргахдаа итгэмжлэгдсэн төлөөлөгчийн харилцах дансанд шилжүүлэх;

6.1.5 аж ахуйн данснаас хувь хүний харилцах дансруу зарлагын гүйлгээ гаргах болон хувь хүний төвлөрсөн хадгаламж дахь дансруу данс хоорондын шилжүүлэг хийх;

Долоо. Арилжааны төлбөр тооцоо

7.1 Арилжааны төлбөр тооцоог Үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын арилжааны баталгаажигдсан хэлцлээр гүйцэтгэнэ. Арилжааны баталгаажигдсан хэлцлийг арилжаа дууссанаас хойш 15 минутанд багтаан сүлжээгээр болон хэвлэмэлээр хүлээн авч, бүртгэл хөтөлнө.

7.2 Хэлцлийг шалган, хүлээн авснаар тухайн өдрийн арилжааны гүйлгээг нэгдсэн санд нөлөөлүүлнэ. Хэлцлийг шалгах явцад алдааг илрүүлэн хэлцэл буцах бол энэ тухай мэдэгдэлийг Хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад албан ёсоор ажлын нэг өдөрт багтаан мэдэгдэнэ.

7.3 Арилжаа нөлөөлүүлснээр тухайн өдрийн арилжааны шимтгэлийн мөнгийг холбогдох эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн гэрээ, журам, тогтоол, хүсэлтийг үндэслэн хэлцэл хийгдсэн тал тус бүрээс суутган тооцоог хийж үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон МХБ, СЗХ, ҮЦТТХТ, БДК, Андеррайтерийн компанийн төвлөрсөн хадгаламж дахь дансанд Т+0 хугацаанд шилжүүлнэ. ЗГҮЦ-ны арилжаанд энэ заалт хамаарахгүй.

7.4 Арилжааны хэлцлийг хүлээн авснаар арилжааны хуулгын санг бэлтгэн текст хэлбэрээр ҮЦТТХТ-ийн дотоод сүлжээнд байрлуулна.

7.5 Гүйлгээ хариуцсан ажилтан БДК-иудын тухайн өдрийн гүйлгээний хуулгыг XLS форматаар, гүйлгээний файлыг VCTF форматыг холбогдох имэйл хаягаар өдөрт 2 удаа /арилжааны хэлцэл нөлөөлсний дараа болон гүйлгээ өндөрлөсний дараа/ БДК-иудад илгээнэ.

Найм. Төлбөр тооцоог гүйцэтгэх

8.1 Алба нь баримт хүлээн авсан дэс дарааллыг баримтлан төлбөр тооцоог цахим тооцоолуурын сүлжээний тусламжтайгаар гүйцэтгэнэ.

Ес. Төлбөр тооцоо хийгдэх хугацаа

9.1 Алба нь арилжааны үнэт цаасны төлбөр тооцоог дараахь хугацаанд хийж гүйцэтгэнэ

9.1.1 Биет бус үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог Т+0 хугацаанд хийж гүйцэтгэх;

9.1.2 Биет үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог Т+2 хугацаанд хийж гүйцэтгэх;

9.1.3 Засгийн газрын болон компанийн бондын төлбөр тооцоог тухайн бонд гаргагчтай байгуулсан гэрээ, холбогдох журмын дагуу;

9.2 Алба нь мөнгөн хөрөнгийн гүйлгээг дараах хугацаанд хийж гүйцэтгэнэ. Үүнд:

9.2.1 биет бус үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог Т+3 хугацаанд;

9.2.2 биет үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог Т+2 хугацаанд;

9.2.3 анхдагч зах зээл дээр гаргасан үнэт цаасны арилжааны төлбөр тооцоотой холбоотой мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг тухайн үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу;

Арав. Төлбөр тооцооны үйлчилгээний шимтгэл

10.1 Төлбөр тооцооны үйлчилгээний шимтгэл, хураамжийг “ҮЦГТТХТ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2006 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 06 тоот тогтоолын 10 дугаар хавсралтын дагуу тооцно.

10.2 Арилжаа эрхлэх байгууллагаар хийгдсэн үнэт цаасны арилжааны хэлцэл нь СЗХ-ны тогтоол болон шүүхийн шийдвэрээр буцах тохиолдолд өмнө тооцогдсон шимтгэлийг үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагуудаас суутгах үүрэг хүлээхгүй.

10.3 Банк хоорондын төлбөр тооцооны үйлчилгээний шимтгэлийг “Монгол банкны хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу харилцагчийн данснаас гүйлгээ тутамд тооцож авна.

Арван нэг. Төлбөр тооцооны тайлан мэдээ

11.1 Төвлөрсөн хадгаламжийн мөнгөн хөрөнгийн тайланг өдөр бүрээр гаргах бөгөөд алба нь төлбөр тооцооны үйл ажиллагааны талаарх тайлан мэдээг дараах байдлаар гаргана. Үүнд:

11.1.1 мөнгөн хөрөнгийн орлогын тайлан /маягт-2/

11.1.2 мөнгөн хөрөнгийн зарлагын нэгдсэн тайлан. /маягт-3/

11.1.3 мөнгөн хөрөнгийн гүйлгээний хураангуй мэдээ /маягт-4/

11.1.4 тухайн өдрийн данс хоорондын гүйлгээний жагсаалт /маягт-5/

11.1.5 мөнгөн хөрөнгийн баланс /маягт-6/

11.1.6 Монгол банкны харилцах дансны орлого, зарлагын гүйлгээний баланс/маягт-7/

11.1.7 Буцаагдсан орлогын жагсаалт /маягт-8/

11.1.8 Амжилттай гүйлгээний жагсаалт /маягт-9/

11.2 Төлбөр тооцооны үйлчилгээний шимтгэл, хураамжийн судалгаа гаргана.

11.3 Албанаас гарах мэдээ, тайлан судалгаа нь албаны менежерээр хянагдсан байна.

Арван хоёр. Баримтын хадгалалт, нууцлалт

12.1 Албанаас гарах мэдээ мэдээллийн хадгалалт, нууцлалыг ажилтан бүр хариуцан ханган ажиллах бөгөөд “ҮЦТТХТ –ийн нууцын тухай журам”, “Мэдээллийн бааз, сүлжээний ашиглалт, нууцлалын тухай журам” –аар зохицуулагдана.

12.2 Төлбөр тооцооны гүйлгээний баримтыг хариуцсан ажилтан нь тухай бүр хавтаслаж, дугаарлан өөрийн цоож, лацтай сейф, шүүгээнд хадгалах бөгөөд “ҮЦТТХТ” ХХК –ийн “Нууцын тухай журам”-д зааснаар архивлах хэмжээнд хүрмэгц нууцын эрхлэгчид хянуулан, архивт шилжүүлнэ.

12.3 Арилжааны хуулгыг өдөр өдрөөр үүсгэн хадгалах бөгөөд холбогдох журмын дагуу архивлана.

12.3 Нууцын эрхлэгч гүйлгээний баримтыг шалган, бүртгэсний дагуу хариуцсан ажилтан архивын ажилтанд баримтаар хүлээлгэн өгнө. Ажилтнууд “Нууцын тухай журам”-д заасан нууцын зэрэглэлд хамаарах баримт бичгийг архиваас авч ашиглахдаа нууцын эрхлэгчид мэдэгдэнэ.

12.4 “ҮЦТТХТ” ХХК нь ажилтан бүрээр нууцлалын баталгаа гаргуулна.

Арван гурав. Хариуцлага

13.1 Үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын арилжааны баталгаажигдсан хэлцэл энэхүү журмын 7.1-д заасан хугацаанд ирээгүй тохиолдолд гарах үр дагаврыг “ҮЦТТХТ” ХХК хариуцахгүй.

13.2 Журмын 4.2, 4.3, 4.4, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.15, 5.16, 5.17, 5.18, 7.2, 6 болон 12-р заалтуудыг зөрчсөн холбогдох ажилтан хариуцлагыг бүрэн хүлээх ба компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар “ҮЦТТХТ” ХХК компанийн Дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

13.3 Мөнгөн хөрөнгийн орлогын гүйлгээнд банкны буруутай үйлдлээс үүдэн гарах аливаа хохирлыг “ҮЦТТХТ” ХХК нь хариуцахгүй.

13.4 Зуучлагч БДК нь анхан шатны баримтын бүрдэл, мэдээллийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.

13.3 Энэхүү журмыг зөрчсөн үйлдэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж зөрчсөн бол Санхүүгийн зохицуулах хороонд, эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

Арван дөрөв. Бусад

14.1 Энэхүү журамд “ҮЦТТХТ” ХХК –ийн ТУЗ –ийн тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулна.

“ҮЦТТТХТ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2006 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 06 тоот
тогтоолын 10 дугаар хавсралт

АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО

Үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын арилжааны хэлцлийн үнийн дүнгийн

Үнэт цаасны төрөл	Үйлчилгээний шимтгэл
Үнэт цаасны зах зээл дээр арилжигдаж буй компанийн бүх төрлийн хувьцаа	Худалдсан болон худалдан авсан тал тус бүрээс 0.24 хувь
Анхдагч зах зээл дээр андеррайтерийн компаниар дамжуулан арилжигдаагүй компанийн бүх төрлийн хувьцаа	Худалдсан талаас нэмж 0.2 хувь
Төрийн өмчийн хувьцаа	Худалдсан талаас 0.3 хувь, Худалдан авсан талаас 0.24 хувь
Компанийн Өрийн бичиг /бонд/	Худалдсан талаас 0.0075 хувь, Худалдан авсан талаас 0.0075 хувь
Засгийн Газар, аймаг нийслэлийн Засаг даргын өрийн бичиг /бонд/	Худалдсан талаас 0.00175 хувь, Худалдан авсан талаас 0.00375 хувь
Банк хоорондын гүйлгээ	Гүйлгээ тугамд 500 төг

ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ДАНСНААС МӨНГӨ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

1. *Төвлөрсөн хадгаламжийн дансны дугаар
2. *Харилцагчийн овог нэр
3. *Иргэний үнэмлэхний дугаар
4. *Регистрийн дугаар
5. Оршин суугаа хаяг
6. Харилцах утасны дугаар

Хувьцааны мөнгө, Бондын мөнгө, -----ХК-ийн ----- оны ногдол

ашиг, ногдол хувийн мөнгө болох/зурах/ -----төгрөг-----мөнгийг
/үсгээр/ -----

-----*банк дахь-----/байгууллага, хүний нэр/

-----*тоот дансанд олгоно уу.

Өргөдөл гаргасан-----

/гарын үсэг/

/харилцагчийн нэр/

Харилцагчийг төлөөлсөн: итгэмжлэгч өөрөө

Хүлээн авсан: БДК-ийн ажилтан: -----

Хянасан: БДК-ийн Гүйцэтгэх захирал: -----

Тамга

20 оны сарын өдөр

Өргөдлийг хүлээн авч, гүйлгээ хийсэн:

ТТЭУА-ны гүйлгээний нягтлан бодогч -----

Хянасан: ТТЭУА-ны Менежер /ахлах нягтлан бодогч/ -----

/тэмдэг/

20 оны сарын өдөр

Мэдэгдэл:

*1-4-ыг заавал бөглөх бөгөөд буруу бөглөснөөс гүйлгээ хийгдэхгүй болохыг анхаарна уу.

*Тухайн харилцагч нь харилцах банкны дугаараа буруу бичсэнээс гарах хариуцлагыг “ҮЦТТТХТ” ХХК хариуцахгүй.

Маягт-2**Мөнгөн хөрөнгийн орлогын тайлан**

огноо

д/д	Данс	Тоо хэмжээ	Хүлээн авагч банк	Гүйлгээний утга

Нийт дүн

Тайлан гаргасан: ТТЭУА-ны ажилтан

/ /

Тайлан хянасан: ТТЭУА-ны менежер

/ /

Маягт -3**Мөнгөн хөрөнгийн зарлагын нэгдсэн тайлан**

огноо

д/д	Овог нэр	ҮЦК-ны код	Дансны дугаар	Шилжүүлгээр	Тайлбар

Нийт зарлагын дүн:

Тайлан гаргасан: ТТЭУА-ны ажилтан

/ /

Тайлан хянасан: ТТЭУА-ны менежер

/ /

Мөнгөн хөрөнгийн гүйлгээний хураангуй мэдээ

огноо

Д/Д	ҮЦК-ны нэр	Орлого		Зарлага	
		тоо	үнэ	тоо	үнэ
	Нийт дүн				

Тайлан гаргасан: ТТЭУА-ны ажилтан / /
 Тайлан хянасан: ТТЭУА-ны менежер / /

..... өдрийн данс хоорондын гүйлгээний жагсаалт

Д/д	Шилжүүлэгч		Мөнгөний дүн	Ширхэг	Хүлээн авагч		Код
	Дансны дугаар	Овог нэр			Дансны дугаар	Овог нэр	

Дүн

Тайлан гаргасан: ТТЭУА-ны ажилтан / /
 Тайлан хянасан: ТТЭУА-ны менежер / /

Мөнгөн хөрөнгийн баланс

огноо

.....

БДК-ийн код	БДК-ийн нэр	Орлого	Зарлага

Дүн

Дүн

Төвлөрсөн хадгаламжийн нийт үлдэгдэл

Эхний үлдэгдэл

Орлого

Зарлага

Эцсийн үлдэгдэл

CDEPO-ийн үлдэгдэл

Баланс

МХБ, ҮЦГТХТ-ийн данснуудын үлдэгдэл

.....

Арилжааны шимтгэлийн данс

Арилжааны бус гүйлгээний данс

Ноогдол ашгийн данс

Нийт

Харилцагчийн мөнгөний үлдэгдэл

.....

Дүн

Тайлан гаргасан: ТТЭУА-ны ажилтан / /

Тайлан хянасан: ТТЭУА-ны менежер /

**ҮЦТТГХТөвийн харилцах дансны орлого,
зарлагын гүйлгээний баланс (Амжилттай, Амжилтгүй)**

Тайлангийн огноо:

Хэвлэсэн огноо: 0000/00/00 00:00:00

Эхний үлдэгдэл: 00,000,000,000.00

Амжилттай

Д/д	Огноо	Дансны дугаар	Орлого	Зарлага	Гүйлгээний утга	Тайлбар
Нийт						

Амжилтгүй

Д/д	Огноо	Дансны дугаар	Орлого	Зарлага	Гүйлгээний утга	Тайлбар
Нийт						

Эцсийн үлдэгдэл: 00,000,000,000.00

Тайлан гаргасан: ТТЭУАлбаны ажилтан: /

Тайлан хянасан: ТТЭУАлбаны менежер: /

**ҮЦТТГХТөвийн харилцах дансны орлого,
зарлагын гүйлгээний баланс (Амжилтгүй)**

Тайлангийн огноо:

Хэвлэсэн огноо: 0000/00/00 00:00:00

Д/д	Огноо	Дансны дугаар	Орлого	Зарлага	Гүйлгээний утга	Тайлбар
Нийт						

Тайлан гаргасан: ТТЭУАлбаны ажилтан: / /

Тайлан хянасан: ТТЭУАлбаны менежер: / /

**ҮЦТТГХТөвийн харилцах дансны орлого,
зарлагын гүйлгээний баланс (Амжилттай)**

Тайлангийн огноо:

Хэвлэсэн огноо: 0000/00/00 00:00:00

Д/д	Огноо	Дансны дугаар	Орлого	Зарлага	Гүйлгээний утга	Тайлбар
Нийт						

Тайлан гаргасан: ТТЭУАлбаны ажилтан: / /

Тайлан хянасан: ТТЭУАлбаны менежер: / /